



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/337

Мөрөн сум

Төсөл арга хэмжээний нэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөв төлөвлөлт-Өгөөжтэй эдийн засаг” арга хэмжээгээр хэрэгжих ажлын жагсаалт, төсөвт өртөг батлах тухай аймгийн Засаг даргын 2022 оны А/14 дүгээр захирамжийн хавсралтын “Худалдан авах ажиллагаанд оролцогч талууд болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдийн төлөөллийг худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамруулах замаар тэдний санхүүгийн мэдлэг чадварыг дээшлүүлнэ” гэсэн хэсгийг “Худалдан авах ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, программ хангамжийг шинэчлэх” гэж өөрчилсүгэй.

2.Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог) нарт даалгасугай

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/14 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан “Худалдан авах ажиллагаанд оролцогч талууд болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдийн төлөөллийг худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамруулах замаар тэдний санхүүгийн мэдлэг чадварыг дээшлүүлнэ” гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН